ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар 7/03 Сайншанд


Хөрөнгө актлуулахаар уламжлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10/16 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 2 төрлийн 2 ширхэг 150,667,209.81 (нэг зуун тавин сая зургаан зуун жаран долоон мянга хоёр зуун есөн төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 42,102,133.11 (дөчин хоёр сая нэг зуун хоёр мянга нэг зуун гучин гурван төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн элэгдэлтэй 108,565,076.70 (нэг зуун найман сая таван зуун жаран таван мянга далан зургаан төгрөг далан мөнгө) төгрөгийн үлдэгдэх өртөгтэй хөрөнгө, Ерөнхий боловсролын сургуулийн дансанд бүртгэлтэй 2 төрлийн 2 ширхэг 25,774,964.26 (хорин таван сая долоон зуун далан дөрвөн мянга есөн зуун жаран дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 13,102,113.78 (арван гурван сая нэг зуун хоёр мянга нэг зуун арван гурван төгрөг далан найман мөнгө) төгрөгийн элэгдэлтэй 12,672,850 (арван хоёр сая зургаан зуун далан хоёр мянга найман зуун тавин) төгрөгийн үлдэгдэх өртөгтэй хөрөнгө, Дэмд-Од ОНӨААТҮГ-ын 3 төрлийн 245 ширхэг 314,000,000 (гурван зуун арван дөрвөн сая) төгрөгийн балансын үнэтэй 32,416,666.40 (гучин хоёр сая дөрвөн зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг дөчин мөнгө) төгрөгийн элэгдэлтэй 281,583,334 (хоёр зуун наян нэгэн сая таван зуун наян гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийн үлдэгдэх өртөгтэй хөрөнгө нийт 7 төрлийн 249 ширхэг хөрөнгийг цаашид ашиглах боломжгүй болсон тул актлуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

- 4626130017

2. Актлах хөрөнгийн материалыг журмын дагуу бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлэхийг сумын өмч хамгаалах орон тооны бус байнгын зөвлөлийн дарга (Р.Чинбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ОГТБИШ